III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- *Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- *Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг бариимтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- *Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- *Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- *Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- *Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд*

бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч тендерт оролцогчоос нийлүүлэх гэж буй барааны үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

ЦАГААНЧУЛУУТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 онд
ХУДАЛДАН АВАХ ХООЛНЫ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023 оны 05 дүгээр сарын 28

Барааны тодорхойлолт: (Хүүхдийн цэцэрлэгт чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх)

1. Стандарт:Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. (Сүүлийн шинэ стандартуудыг үйл ажиллагаанцаа нэвтрүүлсэн байх.)

2. Баглаа боодол: (Барааг зориулалтын унаанд тээвэрлэх зориулалтын зөөвөрлөх, хадгалах савтай байх)

3. Барааг хүргэх газар: “Хүүхдийн цэцэрлэг” *(НИЙЛҮҮЛЭГЧ КОМПАНИ ЗАХИАЛАГЧИЙН ХҮСЭЛТЭЭР ӨДӨР БҮР ӨӨРИЙН УНААГААР ХҮРГЭХ)*

Бараа нийлүүлэлтийн хуваарь: Хүүхдийн цэцэрлэгийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хугацаа, тоо ширхэг техникийн тодорхойлолт

№	Барааны нэр	Стандарт	Тоо ширхэг	Техникийн тодорхойлолт
Багц1. Махан болон сүүн бүтээгдэхүүн				
Мах махан бүтээгдэхүүн				
1	Хонины мах	MNS 5023 : 2001	1200 кг	Мах сайтай тарган, эрүүл, гарал үүслийн бичигтэй байх
2	Үхрийн мах	MNS 5023 : 2001	1200 кг	Мах сайтай тарган, эрүүл, гарал үүслийн бичигтэй байх
Сүү сүүн бүтээгдэхүүн				
3	Сүү	MNS CAC RCP 57 : 2014	1284 л	Эрүүл цэвэр гарал үүсэл шинжилгээний бичигтэй байх
3.1	Тараг	MNS CAC RCP 57 : 2014	200 л	Эрүүл цэвэр гарал үүсэл шинжилгээний бичигтэй байх
4	Аарц	MNS CAC RCP 57 : 2014	150 кг	Эрүүл цэвэр гарал үүсэл шинжилгээний бичигтэй байх
5	Ааруул	MNS CAC	20 кг	Эрүүл цэвэр гарал үүсэл шинжилгээний

		RCP 57 : 2014		бичигтэй байх
6	Зөөхий	MNS CAC RCP 57 : 2014	60 кг	Эрүүл цэвэр гарал үүсэл шинжилгээний бичигтэй байх
7	Цөцгий	MNS CAC RCP 57 : 2014	50 кг	Эрүүл цэвэр гарал үүсэл шинжилгээний бичигтэй байх
8	Молоко	MNS CAC RCP 57 : 2014	60 ш	Шаардлага хангасан хугацаа нь дуусаагүй байх
Үнийн дүн				**14256700**
Багц2. Бусад хүнс				
Нэр төрөл-3 Хүнсний ногоо				
9	Төмс	MNS0270	500 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
10	Байцаа	MNS0255	250 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
11	Лууван	MNS0270	250 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
12	Манжин	MNS0270	1250 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
13	Сонгино	MNS0270	40 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
14	Чинжүү	MNS0270	20 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
15	Помидор	MNS0270	10 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
16	Саримс	MNS0255	3 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
17	Огурцы	MNS0255	20 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх

Жимс жимсгэнэ				
18	Алим		120 кг	Орос улёын бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байна.
19	Чацаргана		50 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
20	Чавга		20 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
21	Аньс		50 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
22	Юуцай		5 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
23	Брокколи	MNS 0257	5 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
24	Чангааанз		10 кг	Монгол хөрсөнд ургасан. Муудаагүй цэвэр байх
25	Варень		80 ш	Муудаагүй цэвэр байх
26	Нимбэг		5 кг	ММуудаагүй цэвэр байх
27	Үзэм		20 кг	Муудаагүй цэвэр байх
Гурил, гурилан бүтээгдэхүүн				
28	I гурил	Хүнсний тухай хуулийн 10,1 10,2	900 кг	Стандартын шардлага хангасан байх
29	II гурил	Хүнсний тухай хуулийн 10,1 10,2	80 кг	Стандартын шардлага хангасан байх
30	Дээд гурил	Хүнсний тухай хуулийн 10,1 10,2	50 кг	Стандартын шардлага хангасан байх
31	Бүхэл үрийн	Хүнсний	35 кг	Стандартын шардлага хангасан байх

	гурил	тухай хуулийн 10,1 10,2		
32	Печень	Хүнсний тухай хуулийн 10,1 10,2	350 ш	Стандартын шардлага хангасан байх
33	Гоймон	Хүнсний тухай хуулийн 10,1 10,2	250 ш	Лапша нэрийн бүдээгдэхүүтэй дүйцэхүйц чанартай байх.
Будаа				
34	Цагаан будаа	MNS ISO 7301 : 2000	140 кг	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
35	Шар будаа	MNS 0533 : 1998	80 кг	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
36	Гурвалжин будаа	MNS ISO 7301 : 2000	80 ш	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
37	Хүүхдийн будаа каша	MNS ISO 7301 : 2000	60 ш	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
38	Хөц будаа	MNS ISO 7301 : 2000	20 кг	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
39	Овьёос	MNS ISO 7301 : 2000	30 ш	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
40	Элсэн чихэр	MNS CAC 212 : 2014	170 кг	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
41	Ургамлын гаралтай тос	MNS CAC 33 : 1998	20ш	Симпли үйлдвэрийн нэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц чанартай сайн тос байх.
42	Оливын тос	MNS CAC 33 : 1998	5 л	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх

43	Масло	ISO 22000	40кг	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
44	Зөгийн бал	MNS 6294 : 2019	40ш	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
45	Сода	MNS 1837 : 2014	30ш	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
46	Далайн байцаа	MNS 6883 : 2020	100 ш	Чанартай стандартын шаардлага хангасан цэвэр байх
47	Цай	MNS 5131 : 2002	15ш	Монгол цай нэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц хадгалах хугацаа дуусаагүй байх
48	Давс	MNS CAC 150 : 2007	90ш	Стандартын шаардлага хангасан хадгалах хугацаа дуусаагүй байх
49	Хөөлгөгч	MNS CAC RCP 1 : 2003	40ш	Стандартын шаардлага хангасан хадгалах хугацаа дуусаагүй байх
50	Сок	MNS 6705 : 2018	10	Стандартын шаардлага хангасан хадгалах хугацаа дуусаагүй байх
Үнийн дүн				**16076700**

Жич: Анхаарах зүйлс.

1. Дээрх хүнсний бүтээгдэхүүнүүд нь баталгаат хугацаа чанарын шаардлага хангасан байх
2. Дээрх бүтээгдэхүүнүүд нь гарал үүслийн гэрчилгээтэй, мэргэжлийн лабораторийн шинжилгээтэй байна.
3. Захиалагчийн хүсэлтээр өдөр бүр барааг тухайн байршилд хүргэх

Хүргэлт хийхгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН

НЯРАВ: Г.АЛТАНГЭРЭЛ